



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 7 дугаар
сарын 21 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар
хот

Бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт хийх тухай

Нэг. Эрхлэх ажлын чиг үүрэг өөрчлөгдөж байгаатай холбогдуулан "Хот тохижилт" компанийг татан буулгаж, түүний батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан "Гэрэлтүүлэг чимэглэл", "Цэцэрлэгжилт", "Улаанбаатар-зам засвар", "Нөөц" компанийг 1998 оны 8 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулж, аж ахуйн тооцоон дээр ажиллуулахыг Улаанбаатар хотын ерөнхийн менежер (н.Гомбожав)-т зөвшөөрсүгэй.

Хоёр. Хотын инженерийн шугам сүлжээ болон соёл нийгэм, ахуйн барилга байгууламжийг сайжруулж, өргөтгөх ажлын хэмжээ улам нэмэгдэж барилгын ажилд мэргэжлийн захиалагч байгууллагын хяналтыг хүчтэй болгон хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх шаардлагыг үндэслэн Өмчийн газрын хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн товчоог Хөрөнгө оруулалтын газар болгон Улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр Захирагчийн ажлын албаны харьяанд ажиллуулсугай.

Гурав. Дээрх компаниуд, газрын дүрмийг 1998 оны 8 дугаар сарын 25-ны дотор боловсруулж шийдвэрлүүлэхийг Захирагчийн ажлын алба (н.Гомбожав)-нд даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх тухай" нийслэлийн Засаг даргын 1997 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Б/124 тоот захирамжийн 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ